

## МАРТАГДАШГҮЙ ӨДРҮҮД

Д. Дүнгэр-Яйчил

БНХАУ тунхагласны 40 жилийн ой болж байна. Өнгөрсөн 40 жилд эрхэлж ирсэн ажил хөдөлмөр маань Монгол-Хятадын харилцаатай ямар нэг хэмжээгээр холбоотой байлаа. Ямарваа нэг хүн үзсэн харсан, сонсож мэдсэн, бодож санаснаа олонтойгоо хуваалцах нь сайхан. Учир иймд дээр хөндсөн зүйлтэй холбогдол бүхий санал бодол, туулж өнгөрүүлсэн болон харж үзсэнээсээ заримыг нь дор сийрүүлж Та бүхэнд толилуулъя гэж хичээсэн юм.

Хүн төрөлхтний түүх бичигдэн бичигдсээр улирах цагийн эрхээр манай эринд хүрч ирэв. Бидний аж төрж байгаа энэ зуунд хүний нийгмийн хөгжлийн түүхэнд гайхамшигт шинэ хуудсууд олноор нэмэгдсэнийг хэн бүхэн мэдэх билээ. Тийм хуудсуудын нэг нь одоогоос 40 жилийн өмнө дорнодахины түүхэнд бичигдсэн юм. Тэр нь Хятадын ард түмэн Коммунист намынхаа удирдлагаар олон улсын ажилчин анги, хөдөлмөрчдийн интернационалч тусламж дэмжлэгтэйгээр феодализм, империализмын эсрэг олон жилийн турш хийсэн шудрага тэмцлийн үр дүнд дотоод гадаадын дайсны давхар дарлал мөлжлөгийг таягдан хаяж, улмаар хувь заяаныхаа жинхэнэ эзэн нь болсон тухай түүхт хуудас юм. Хятадын ард түмний баатарлаг тэмцлийн ялалт дорнодахины төдийгүй, бүх дэлхийн дарлагдсан ард түмний империализм, колоницлолын эсрэг хийж байсан ариун тэмцлийг улам зоригжуулсан юм.

Тэрхүү тэмцэл ялалтынхаа босгонд тулж очсон үеийн хэсгээс цаашид өгүүлэх зүйлээ товч дурдъя. 1949 он гарав. Хятад дахь иргэний дайн гурав дахь жилийнхээ нүүрийг үзээд байсан 3-р сар дундаа орлоо. Хятадын ардын нөлөөлөх армийн (ХАЧА) давшилт алхам бүрдээ амжилт олж байлаа. Яг энэ үед ер бусын нэгэн үйл явдал болжээ. Чан Кайшийн өндөр итгэл найдварыг хүлээж, умарт Хятад дахь гол хүч болж байсан генерал Фу Зои ХАЧА-д буун өгч, Хятадын эртний нийслэл Бээжин хотыг сумны хэлтэрхий ч хүргэлгүй Хятадын ард түмний гарт эгүүлэн тушаасан юм. Бээжин хотыг тайван замаар чөлөөлсөн явдал Чан Кайшийн хувьд цэлмэг өдөр аянга буусантай адил санамсаргүй хэрэг болсон тул тэрээр Жан Жижүн тэргүүтэй Гоминданы Засгийн газрын энх тайвны хэлэлцээ хийх төлөөлөгчдийг Бээжинд томилон явуулжээ. ХКН хэлэлцээ хийх 8 болзол дэвшүүлсэн ба Чан Кайшийн засгийн газар түүнийг хүлээж авахаас татгалзсан тухай 4-р сарын 20-нд мэдэгдсэн тул ХАЧА-н ангиуд дээд командлалын тушаал ёсоор 4-р сарын 21-нд бүх фронтоор давшиж, 300 мянган хүнтэй гол хүчин 22-ны өдөр гэхэд Хөх мөрнийг гаталж, 23-нд Нанжин (тухайн үед Гоминьданы нийслэл) хотыг чөлөөлж, тэр эрчээрээ өмнө зүг давшиж ялалтаас ялалтад хүрч байлаа. Энэ хугацаанд ХКН-ын удирдагчид ардчилсан нам, бүлэг, байгууллагуудын удирдах зүтгэлтнүүдтэй уулзалт яриа хийж, улмаар Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлгөөнийг (ХАУТЗЗ) зарлан хуралдуулахаар ярилцан тохирсон байна. Ингээд 1949 оны 9-р сарын 21-30 хүртэл уг зөвлөлгөөний анхдугаар бүгд хуралдааныг хийж, ардын бүгд найрамдах улс байгуулах эрхзүйн бүх асуудлыг шийдвэрлэсэн байна. Тухайлбал улсын нэр, төрийн сүлд, далбаа, сүлд дуулал, БНХАУ-ын Ардын Төв Засгийн газрыг эмхлэн байгуулах дүрэм, ХАУТЗЗ-ны нийтийн программ (үндсэн хуулийн үүрэг гүйцэтгэх баримт бичиг) зэрэг засаг төрийг цогцлон байгуулах үндсэн баримт бичгүүдийг батлав.

1949 оны 10-р сарын 1. Хятадын олон мянган жилийн түүхэнд үндсэн эргэлт болсон өдөр юм. Хятадын ард түмэн хуучин нийгмийн дарлал мөлжлөгийг эгнэгт халж, эрх жаргал хөгжил дэвшлийн замд эргэлтгүй орсон өлзийтэй өдөр юм.

40 жилийн тэртээх энэ өдөр Бээжингийн Тяньаньмэний талбайд түг түмэн хүн цугларсан байлаа. Жагсагч олны барьсан өнгө өнгийн далбаа дарцаг зөөлөн салхины аясаар намиран хийссэн нь цэцгийн далай давалгаалах мэт үнэнхүү сайхан харагдаж байлаа. Сайн санаат хүмүүсийн хүндэтгэлийг хүлээсэн баяр ёслолд оролцож байгаадаа тэр үү, эсвэл тодорхой хугацаанд Хятадын ард түмэнтэй зовлон жаргалаа хуваалцаж явсан болоод тэр үү, ямар ч байсан сэтгэл ихэд хөдөлж, баясал бахдал давхцаж байсан мөчүүд одоо тодхон санагдаж байна.

Тяньаньмэний урд байдаг цагаан хаш чулуун гүүрний зүүн, баруун хоёр талд асар босгож, тэнд гадаад дотоодын зочид төлөөлөгчид байраа эзэлж баярт мөчийг хүлээж байлаа.

15 цаг болов. БНХАУ-ын Ардын Төв Засгийн газрын дарга Мао Зэдун түүний орлогчид Жүдэ, Лю Шаоци, Сун Цинлин, (Сунь Ятсены гэргий) Ли Зишэнь, Жан Лань, Гао Ган нар болон төрийн зөвлөлийн ерөнхий сайд Жоу Эньлай нар Тяньаньмэний индэр дээр гарч ирэв. Ардын Төв Засгийн газрын хариуцлагатай нарийн бичгийн дарга Линь Боцюй БНХАУ-ыг тунхаглах баяр ёслолын ажиллагаа нээснийг мэдэгдсэний дараа Мао Зэдун микрофоны өмнө очиж «БНХАУ ын Ардын Төв Засгийн газар байгуулагдав» гэж мэдэгдэн тэр өөрөө БНХАУ-ын төрийн далбааг мандуулав. Индэрийн тус газар цахилгаан товчлуур зоосон байжээ. Тэр товчлуурыг Мао Зэдун дарахад таван алтан шаргал таван хушуутай улаан далбаа төрийн сүлд дууллын аясаар талбайн голд зоосон багана өөд алгуурхан өгсөж байсныг түм түмэн нүд ширтэж байв. Энэ үед ёслолын буудлагын нүргээлт дуу хүмүүсийн сэтгэлийг улам ч бадраан догдлуулж байсан нь мэдээж ээ! Хожим уншсан номонд бичсэнээр бол 54 их буугаар 28 удаа буудлага хийсэн ажээ. 54 гэдэг нь ХАУТЗЗ-нд оролцсон нам, байгууллагуудын тоо юм гэнэ.

Дараа нь БНХАУ-ын Ардын Төв Засгийн газрын анхдугаар мэдэгдлийг Мао Зэдун уншив. Тэр мэдэгдэлд БНХАУ-ын Засгийн газар бол Хятадын ард түмнийг төлөөлөх цорын ганц хууль ёсны засгийн газар мөн болохыг дэлхий дахинд ёс төртэй зарлаж, эрх тэгш харилцан ашигтай, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх зарчмын үндсэн дээр дэлхийн улс бүхэнтэй дипломат харилцаа тогтооно гэж мэдэгджээ.

Цэргийн парад эхлэв. ХАЧА-н ерөнхий командлагч Жү Дэ парадад оролцох анги нэгтгэлүүдийн өмнүүр машинаар явж баяр хүргэсний дараа Тяньаньмэний индэр дээр гарч парад эхлэх тушаал өгөхөд явган цэрэг, морин цэрэг, танк, их бууны ангиуд ээлж дараагаараа индэрийн өмнүүр сүр жавхлантай явж өнгөрөв. Танкийн цуваа алгуурхан жагсан явж байтал нэгэн танк яг индэрийн урдхан хүрч ирээд зогсчихлоо. Тэгтэл хэд сайн хар утаа хаялснаа хөдөлж эгнээнд оров. «Одоо яадаг билээ» гэж бачимдсан хүмүүсийн сэтгэл замхарч байгаа хар утаатай адил аажмаар тайтгарсан биз ээ.

Бээжингийн цэргийн тойргийн дарга Не Жунжэний командалсан цэргийн парад 3 цаг үргэлжилж 18 цагт дуусав. Нар баруунаа хэлбийж бүрэнхий боллоо. Тэгтэл талбайн дөрвөн зүг найман зовхисоос нэгэн зэрэг гэрэл асаж, их баярын талбай дахин өдөр мэт гэгээн саруул болов.

Хөдөлмөрчдийн жагсаал эхлэв. Анхны жагсаал гэхэд тун ч эмх цэгцтэй, зохион байгуулалттай болсон нь одоо ч тодхон санагдаж байна. «БНХАУ мандтугай», «Мао дарга мандтугай» гэсэн уриа цууриатаж, баяр хөөр бялхаж байсныг одоо эргэн санахад Хятадын ард түмэн тэгэхэд Мао Зэдунг үнэнхүү хүндэлж байсан байжээ.

22 цаг боллоо. Жагсаал шувтрах дөхөв. Жагсагчдын сүүлчийн хэсэг Тяньаньмэний өмнө цугларан зогсож завсар зайгүй «Мао дарга мандтугай» гэсэн ерөөл дэвшүүлэхэд Мао Зэдун индэр дээрээс «Нөхдүүд мандтугай», «Ард түмэн мандтугай» гэж хариу ерөөж байснаас үзэхэд тэр тухайн үедээ нөхөдтэйгөө, ард түмэнтэйгээ хамт байсны баримт мөн болов уу.

10-р сарын 2-ны өдөр БНХАУ тунхаглагдсаны дараахи анхны урлагийн арга хэмжээ болов. Энэ өдөр Бээжин оперийн нэрт жүжигчин Хятадын үндэсний урлагийн их мастер Мэй Ланьфаны тоглолт болов. Энэ ч гэсэн нарийн учир шалтгаантай. Японыг эсэргүүцсэн дайн эхэлмэгц Мэй Ланьфан тэр тэмцэлд сэтгэл санаагаараа нэгдэн орж, тайзнаа гарахаас цээрлэж олон жилийн турш үзэгч олноос хөндий явжээ. Хятадад ардын хувьсгал ялж, ард түмэн эрх чөлөөгөө байлдан олсон, түүхэн их баяр ёслолд зориулж ая дуугаа барьж эхэлсэн нь тэр байжээ.

Түүний тоглолт Жуньнанхайн Хуай рэньтан ордонд болжээ. Хүмүүс суудлаа эзлэв. Тэгтэл тайзны зүүн гар талын хаалгаар хэдэн хүн орж ирсний нэг нь Мао Зэдун байв. Тэр хоёрдугаар эгнээний зүүн талаас гуравдахь суудалд суусан шиг санагдаж байна.

Мэй Ланьфан хэмээх нэрийг урд өмнө олонтоо дуулсан боловч тоглолтыг анх үзэж суусан маань тэр билээ. Эмэгтэй хүний дүрд гарамгай тоглодог тэр хүн Хятад орноор үл барам дэлхий дахинд алдартай бөгөөд 1930-аад оны үед Москвагийн эрдмийн их хүрээлэнд тоглож, Зөвлөлтийн урлагийн нэрт зүтгэлтэн Станисловскийн дотнын найз болсон юм.

Тэр үед гадна дотны ил далд дайсан олон байсан нь мэдээж. Аюулгүй байдлыг хангах зорилгоор Хуай Рэньтан ордонд орох зуур дөрвөн хаалга дамжсан ба хаалга бүрт нэвтрэх үнэмлэх сольж олгож байж билээ.

1949 оны 10-р сарын 6. БНМАУ-ын Засгийн газар БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч төдөлгүй хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоов. Тэр тухай мэдээг «Жэньминь жибао» сонинд нийтлэв. Монгол, Хятад хоёр улсын хооронд анхны эрх тэгш харилцаа тийнхүү тогтсоныг мэдээд тэсгэлгүй баярлаж явсан тэр хурам өчигдөрхөн болоод өнгөрсөн юм шиг тодоос тод санагдаж байна. 1949 оны мартагдашгүй өдрүүдээс заримыг эргэн санахад ийм байна.

Ардын эрхт төрийн 40 дэх хавар—1989 оны 4, 5-р сард Хятад орноор аялах бололцоо олдов. 1985 оны 8-р сард зуны амралтаараа Токиогоос эх орондоо буцах замд Бээжинг дайран өнгөрснийг эс тооцвол 25 жилийн дараа БНХАУ-ын умарт хилийн Эрээн хотоос өмнө зүгийн Шэньжэнь хот хүртэл аялж газар үзэн нүд тайлав. Сүүлийн 10 жилд тууштай хэрэгжүүлсэн өөрчлөлт шинэчлэлтийн бодлогын үр дүнд Хятадын ард түмэн урьд өмнө байгаагүй амжилт олсон байна.

Социализм цогцлон байгуулах хэрэгтээ улам их амжилт олохыг энэ дашрамд чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.